

Мэндчилгээ

2012.04 Дугаар 3

Гарчиг

 Project E-News

【Улаанбаатар хотын газар хөдөлтийн эрсдлээс хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл】

Төсөл хариуцсан ажилтан Э. Булган

 Volunteer E-News

【Монголд ажиллаж буй Японы сайн дурын гишүүний танилцуулга】

Сайн дурын гишүүн хариуцсан ажилтан
Ц. Орхонтуяа

 Сургалт төгсөгчдийн булан

Сургалт төгсөгч Д. Нямсүрэн

 Нэмэлт мэдээлэл

[2012 оны сэдэвчилсэн сургалтын жагсаалт](#)

[Ярилцлагад орсон сургалт төгсөгчдийн жагсаалт](#)

Бэлтгэсэн : Х. Түвшин-Од

Жайка Монгол дахь Төлөөлөгчийн Газар

Улаанбаатар хот, Сүхбаатарын талбай 3,

Бодь цамхаг 7 давхар

Утас: 325939, 312393

Факс: 310845

E-mail: mg_oso_rep@jica.go.jp

<http://www.jica.go.jp/mongolia/index.html>



Та бүхний энэ өдрийн амар амгаланг айлтгая. Намайг Исогай Тошинори гэдэг. Миний бие 2010 оны 8-р сараас Жайка-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газрын даргаар томилогдон ажиллаж байна.

Өнгөрсөн жил та бүхний дэмжлэгтэйгээр богино хугацаанд олон семинар зохион байгууллаа. Өмнөх дугаарт та бүхнийг төслийн саналаа ирүүлэхийг хүсч байсан ба нийт 52 сургалт төгсөгчөөс санал ирсэнээс 7 семинар, 1 тоног төхөөрөмжийн хамтын

ажиллагаа хэрэгжсэн. Хэрэгжсэн семинар болон тоног төхөөрөмжийн хамтын ажиллагааны талаар дэлгэрэнгүйг [энэ](#) –д дарж үзнэ үү.

Үүний зэрэгцээ та бүхнээс Жайка-ийн сургалт төгссөний дараах ажлын амжилтынхаа талаар мэдээлэл ирүүлэхийг мөн хүсч байсан ба мэдээлэлээ ирүүлсэн хүн бүхэнд талархал илэрхийлье. Та бүхний ачаар Монгол улсад сургалт төгсөгчдийн сургалтын дараах судалгаа амжилттай хэрэгжсэн бөгөөд Жайка-гийн сургалт төгсөгчдийн амжилтыг нэгтгэсэн танилцуулгыг 5 сард гаргах төлөвлөгөөтэйгээр бид ажиллаж байна. Судалгааны үеэр Монголын 11 сургалт төгсөгчтэй ярилцлага хийн, энэ дундаас Ус сувгийн удирдах газрын ажилтан Лхамаасүрэнгийн талаар танилцуулгад оруулахаар болсон. Бас тус сонины төгсөгчдийн буланд сургалтаа төгссөний дараа маш идэвхтэй үйл ажиллагаа явуулж буй Клиникийн нэгдсэн II эмнэлгийн сувилахуйн албаны дарга Д. Нямсүрэнгийн ярилцлагыг хүргэж байна. Заавал сонирхон уншаарай.

Мөн энэ жил Монгол улс, Япон улсын хооронд дипломат харилцаа тогтоосны 40 жилийн ой тохиож байна. Өнгөрсөн 2-р сарын 1-нд шадар сайд М.Энхболд болон Япон улсаас Монгол улсад суугаа Онц бөгөөд бүрэн эрхт элчин сайд Шимизү Такэнори нар Монгол улсын гадаад харилцааны яаманд хэвлэлийн бага хурал хийн, “Монгол Японы найрамдалт харилцаа тогтоосны 40 жил”-ийн ойн арга хэмжээг албан ёсоор эхлүүлсэн билээ. Түүнчлэн 2012 оны хувьд ЖАЙКА-аас Монгол улсад далайн чанад дахь сайн дурын гишүүн илгээсний 20 жил, Монгол Япон төв байгуулагдсаны 10 жил, Жайка-ийн Монгол дахь Төлөөлөгчийн газар байгуулагдсаны 15 жил зэрэг хэд хэдэн тэмдэглэлт ой давхцсан жил болж байна.

Эцэст нь 4 дүгээр сар бол Японд сакура цэцэглэж эхэлдэг мөн санхүүгийн шинэ жил эхэлдэг сар юм. Би ч гэсэн та бүхэнтэй Монголын хөгжлийн төлөөх шинэ жилийг эхлүүлж байна. Та бүхний ажил, амьдралд амжилт хүсье.

【Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл】

Нийслэл Улаанбаатар хотод газар хөдлөлт бараг мэдрэгддэггүй байсан боловч 2005 оноос хойш үл мэдрэгдэх газар хөдлөлт ихсэх хандлагатай болж, 2009 оноос эрс нэмэгдэж буй нь ШУА-ийн ООГСТ-ийн судалгаагаар тодорхой болсон. Мөн 2010 онд Франц Улсын судалгааны хүрээлэнгээс хэрэгжүүлсэн судалгаагаар Улаанбаатар хотын эргэн тойронд шинээр илэрсэн хагарлыг оролцуулан 7 магнитудтай тэнцэхүйц газар хөдлөлт үүсгэх магадлалтай 4 хагарал байгаа нь тогтоогдсон. 2000 онд Монгол улсын ШУА-аас явуулсан судалгаагаар Улаанбаатар хотын барилга байгууламжуудын насжилт, бат бэх байдал, газар хөдлөлтийг тэсвэрлэх чадварын өнөөгийн нөхцөл байдалд М7-тай тэнцэхүйц газар хөдлөлт болбол, 300 байшин нурж, 60000 иргэн хохирол амсах магадлалтай гэсэн тооцоо гарсан байна.

Ийнхүү газар хөдлөлтийн гамшгийн эрсдэл үүссэн нөхцөл байдалд Монгол Улсын Засгийн газраас 2010 онд Япон Улсын Засгийн газарт хандан “Гамшгаас хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл” хэрэгжүүлэх хүсэлт тавьсан бөгөөд 2011 оны 10 сард төслийн хамрах хүрээ, агуулга, хэрэгжүүлэх бүтэц, зохион байгуулалтын талаар холбогдох байгууллагуудтай ярилцан тохиролцон, хэлэлцүүлгийн тэмдэглэлд гарын үсэг зурж, 2012 оны 3 сараас “Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс хамгаалах чадавхийг бэхжүүлэх төсөл”-ийг хэрэгжүүлж эхэлсэн. Тус төслийн гол зорилго нь Улаанбаатар хотын гамшгийн эрсдлээс хамгаалах чадавхийг бэхжүүлэхийн зэрэгцээ хамтран ажиллах байгууллагуудын ажилчдын техник, ур чадварыг дээшлүүлэх явдал юм.

Газар хөдлөлтийн эрсдлийн нэгдсэн зургийг боловсруулах

Газар хөдлөлтийн гамшгийн эрсдлээс хамгаалах арга хэмжээнүүдийг авахын зэрэгцээ Улаанбаатар хотод газар хөдөлбөл ямар хохирол үүсч болох талаар төсөөлөлтэй байх хэрэгтэй. Монгол улсын засгийн газрын гамшгаас хамгаалах чадавхийг дээшлүүлэх төлөвлөгөөний хүрээнд ШУА-ийн ООГС-ийн боловсруулсан газар хөдлөлтийн бичил мужлалын зурагт үндэслэн, эрсдлийн зураг боловсруулна.

Дунд-өндөр давхаржилтын барилгуудыг газар хөдлөлтөд тэсвэртэйгээр барих гарын авлагын төсөл боловсруулах

Улаанбаатар хотод газар хөдлөлт болсон тохиолдолд дунд, өндөр давхарын хуучирсан барилгууд хамгийн их сүйдэх магадлалтай. Тус төслийн хүрээнд хот байгуулалтын төлөвлөгөөг эргэн харж, барилгуудыг газар хөдлөлтөд тэсвэртэйгээр барих гарын авлагын төсөл боловсруулна.



Улаанбаатар хотын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах удирдлагын төлөвлөгөөг сайжруулах

Одоогийн бодлого, төлөвлөгөөг судалж, холбогдох газар хэлтсүүдтэй хамтран, сайжруулах шаардлагатай зүйлүүдийн талаар санал боловсруулна.

Холбогдох байгууллагууд ба хотын оршин суугчдын газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах чадавхийг сайжруулах, сурталчлан таниулах үйл ажиллагаа явуулах

Нийгмийн систем, байгууллага, хувь хүний гамшгаас хамгаалах чадавхийн өнөөгийн байдалд үнэлгээ хийж, түүний үр дүнд үндэслэн зааварчилгаа, зөвлөмж өгөх замаар чадавхийг хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлэх чиглэлээр хамтран ажиллана.

WHAT IS CBDRM (COMMUNITY-BASED DISASTER RISK MANAGEMENT)?



Бусад үйл ажиллагаа

• 2 сарын 1-11-нд холбогдох байгууллагуудын төлөөлөл 16 хүнийг оролцуулсан семинар сургалтыг Япон улсад зохион байгуулсан.

• 3 сарын 21-22-нд НЗДТГ, ОБЕГ болон холбогдох байгууллагуудтай хамтран, яам, тамгын газрын ажилчид, иргэдийн төлөөллийг оролцуулсан “Газар хөдлөлтийн гамшгаас хамгаалах, хохирлыг бууруулах хамтарсан семинар”-ыг зохион байгуулсан. Мөн 3 сарын 22-нд ОБЕГ-аас эрт зарлан мэдээлэх систем ашигласан нүүлгэн шилжүүлэлтийн сургуулилт хийсэн бөгөөд энэ үеэр ОБЕГ-тай хамтарч, орон сууцанд оршин суугчдад зориулсан “Каэрү Кярабан” Японы гамшгаас хамгаалах иргэдийн үйл ажиллагааг зохион байгуулсан.



【 Монголд ажиллаж буй Японы сайн дурын гишүүний танилцуулга】

Өнөөдөрийн байдлаар монголд нийт 79 сайн дурын гишүүн төрөл бүрийн салбарт ажиллаж байгаагаас энэ удаагийн дугаарт нийслэлийн тэргүүний 22-р цэцэрлэгт ажиллаж буй залуу сайн дурын гишүүн Цүсэ Мисүзүгийн ажлын тухай товч сонирхуулъя.

1. Та өөрийгөө товч танилцуулаач?

Намайг Цүсэ Мисүзү гэдэг. Би 25 настай. Японы Хёго мужад төрсөн. Монголд ирэхээсээ өмнө 3 жил хувийн цэцэрлэгт ажиллаж байсан. Монголд 2010 оны 9 сараас 2 жилийн хугацаатай томилогдон ажиллаж байна.

2. Ажлын тухай?

Би нийслэлийн тэргүүний 22-р цэцэрлэгт багшаар ажиллаж байна. Манай цэцэрлэг 2-5 насны 600 орчим хүүхэдтэй, нийт 46 багш ажилчидтай. Миний хувьд бүх ангиудад дуу хөгжим болон гар урлалын хичээлээр дамжуулан “гарын дор зүйлийг ашиглан тоглох”, “хүүхдийг сэтгэн бодох чадварыг дээшлүүлэх” зорилготой хичээл заадаг. Мөн багш нарт хүүхдүүд гараа хэрхэн зөв угааж сурах гэх мэт ахуйн хичээлийн заах аргыг зааж, мөн хичээлд ашиглаж болох тоглоом болон эцэг эхчүүдэд Японы цэцэрлэгийн боловсролын талаар сурталчлах гэх мэт ажлуудыг хийж байна.

3. Япон болон Монголын цэцэрлэгийн боловсролын ялгаа юу вэ?

Монголд зааж буй цэцэрлэгийн боловсрол гэдэг нь яг л Японы бага сургуулийн хичээлийг санагдуулам. Тоо, монгол хэл, дуу хөгжим, биеийн тамир, зураг гар урлал гэх мэт хичээл ордог. 2 настай анги ч гэсэн ширээнд сууж хичээл хийдэг. Хүүхдийг хичээлийн бус цагаар чөлөөтэй тоглуулдаг цэцэрлэг байдаг ч гэнэт өөр хичээл оруулж бэлтгэсэн тоглоомоо явуулах боломжгүй үе ч гардаг. Японд бол цэцэрлэгийн хүүхдэд бүх амьдарлын турш байнга хэрэглэгдэх гараа зөв угаах, зөв бие засах гэх мэт ахуйн соёлыг заахыг эрхэмлэдэг бол монголд хичээл бол хичээл, ахуйн соёлыг гэртээ сурах ёстой гэж үздэг.

4. Монголд ажиллах хугацаанд тохиолдсон баяртай мөч болон бэрхшээлтэй зүйл чинь юу байсан бэ?

Анх ажилд ороход хүүхдүүд “япон багшаа” гэж дууддаг байсанаа аажимдаа миний нэрийг цээжилж, мэндэлж, надтай ярилцдаг болсон үе хамгийн сайхан санагдаж байна. Мөн эцэг эхчүүдийн ярианаас хүүхдүүд гэртээ миний заасан хичээлийг ярьж өгсөн зэргийг сонсоод тэдний дунд өчүүхэн ч гэсэн миний орон зай



байгааг мэдрэх хамгийн баяртай байсан. Хэцүү бэрхшээлтэй зүйл гэвэл хэлний бэрхшээл л байна. Багш нарт хичээл заахад бага зэргийн чухал нюансыг гүйцэт илэрхийлж чадахгүй байх болон хүүхдүүдийн шулганахыг сайн ойлгохгүй, ойлгосон ч амархан үгээр л хариулдаг болохоор үнэхээр харамсалтай санагддаг.

5. Гадны хүний нүдээр харахад одоогийн Монголын цэцэрлэгт сайжруулах зүйл юу байна вэ?

Зөндөө байна л даа. Сайжруулах зүйл гэхээсээ илүү маш их идэвхтэй багш зөндөө байдаг боловч нэг анги дахь хүүхдийн тоо маш их, хийх ёстой зүйлс олон, бэлдэх шаардлагатай бичиг цаасны ажил маш их байдаг гэдгийг ажиллах хугацаандаа ойлгосон. Тийм учраас ийм нөхцөлд ажиллаж буй багш нарыг ойлгож, тэдэнд тусалж, хамтран ажиллаж гэж бодож байна. Цаашид үлдсэн хугацаандаа багш хүүхдүүд бүгдээрээ хөгжилтэй цагийг өнгөрүүлэх хичээлийг багш нартай хамтарч заах төлөвлөгөөтэй байна. Ямар хөгжилтэй юм бэ гэж мэдрэхээр тийм сонирхолтой хичээлийг заахыг хичээх болно.

6. Буцахаасаа өмнө хийж үзье гэсэн зүйл байгаа юу?

Ирсэн эхний жилийн шинэ жилээр хүүхдүүдтэй хамт “Ёсакой” гэдэг япон бүжгийг хийсэн. Тийм болохоор энэ жилийн шинэ жилээр би өөрөө монгол бүжиг сураад хүүхдүүдтэй хамт бүжиглэх юмсан гэж бодож байна.

7. Сургалт төгсөгчидөд хандаж ямар нэгэн хэлэх зүйл байна уу?

Ажил маань бодож төлөвлөсөний дагуу явахгүй үе байдаг ч хүүхдүүдийн хөөрхөн инээмсэглэлд тэтгэгдэж нэг л мэдэхэд энэ жил 2 дахь өвлөө угтан, монголын хүйтэн бөгөөд урт өвлийн улирлыг монгол хүмүүсийн халуун сэтгэлээр дулаацаж өнтэй давлаа. Та бүхэнд ажлын амжилт, эрүүл энхийг хүсье.



Доржжанцангийн Нямсүрэн
Клиникийн нэгдсэн II эмнэлгийн
сувилахуйн албаны дарга

2010 оны сургалт: Сувилахуйн удирдлага (B)

【Сургалт төгсөгч болон оролцсон сургалт】

2010 оны 9 сараас 12 сар хүртэл сувилахуйн удирдлага сургалтанд оролцсон. Клиникийн нэгдсэн II эмнэлгийн сувилахуйн албаны даргаар ажиллаж байна.

【Сургалтын үр дүн】

Хувь хүний түвшинд : Сургалтын агуулга, лекц, танилцах аялал, бусад сургалтанд оролцогчидтой санал солилцох зэрэг миний хувьд бүхий л зүйл анхных байсан. Ялангуяа workshop зохион байгуулах (хэд хэдээрээ групп болон мэтгэлцээн хийж, үр дүнгээрээ илтгэл тавих), хичээлийн агуулга тус бүрээр агуулгыг нь мартаггүйн тулд тайлан бичдэг нь шилдэг сургалтын арга байна гэж үзсэн учраас ажилдаа нэвтрүүлж байгаа.

Байгууллага, тогтолцооны хэмжээнд : Японы эрүүл мэндийн систем болон шинэ сувилалчид зориулсан боловсролын тогтолцоог өөрийн эмнэлэгт нэвтрүүлэхээр ажиллаж байна. Монголын эмнэлгүүдэд шинэ боловсон хүчинд чиглэгдсэн хичээлийн хөтөлбөр байхгүй тул шинэ сувилалч болон ахмад сувилалч адилхан сургалтанд суух болдог ба эцсийн дүндээ шинэ сувилалчийн дутуу дулимаг ур чадвар асуудал болж байсан юм. Буцаж ирсний дараа хийсэн хамгийн эхний алхам бол нэг сар ээлжийн амралтаа аван сургалтаар олж авсан мэдлэг, туршлагадаа тулгуурлан “Шинэ сувилалч” гарын авлага бэлтгэн, 300 хувийг өөрийн зардлаар хэвлүүлсэн. Энэ нь одоо албан ёсоор Клиникийн нэгдсэн II эмнэлгийн шинэ сувилалч нарт зориулсан сургалтын материал болон ашиглагдаж байна.

Хөгжлийн бодлогын түвшинд : Шинэ сувилалч нарт зориулсан гарын авлагын тухайд аль хэдий нь харьяалагдах эмнэлэгт маань ашиглагдаж байгаа бөгөөд танилцуулах семинар зохион байгуулах зэргээр нийт орон даяар нэвтрүүлэхээр ажиллаж байна. Энэ нь ажил хэрэг болвол Монгол улсын сувилахуйн боловсрол, цаашлаад сувилахуйн технологид дэвшил болно гэж найдаж байна.

Миний ажлын карьерын тухайд сургалт төгсөөд өнөөг хүртэлх ажлын туршлага, сургалтын агуулгад тулгуурлан сувилахуйн менежментийн сэдвээр докторын диссертация бичиж байна.

【Шууд бус үр дүн】

Монголтой ялгаатай нь Японы сувилалч нар өвчтөнтэй их ойр байдаг нь хүчтэй сэтгэгдэл төрүүлсэн. Эмч өвчнөө эмчлэн, сувилалч өвчтнөө сувилах үүрэгтэй тул сувилалчийн хувьд өвчтөнтэй харилцах харилцаа маш чухал юм. Миний хувьд Японы сувилахуй бол дэлхийд топ зэрэглэлдээ орно гэж боддог. Эдгээр агуулгыг өөрийн номондоо багтааж өгсөн тул Япон ёс суртахуун Монгол сувилалч нарын дунд нэвтрээсэй гэж хүсэж байна. Мөн зүүн Японы их газар хөдлөлтийн үед сургалт хэрэгжүүлсэн Олон улсын сувилалч нарын холбоонд эмгэнэл явуулах зэргээр Японтой харилцах харилцаагаа нандигнан хадгалж үргэлжлүүлэхийг хүсдэг.

【Сургалтын үр дүн гарсан шалтгаан】

Сургалтанд оролцогчийн тухайд : Сувилалчаар ажиллаж эхэлсэн тэр үеэс Монголын сувилахуйн салбарыг сайжруулахад хувь нэмрээ оруулахыг чин сэтгэлээсээ зорьж ирсэн. Улмаар би мастериин зэргийг Монголдоо анх удаа хамгаалан, докторантад элсэн суралцаж байгаа анхны сувилахуйн мэргэжилтэн билээ. Сувилахуйн мэргэжлийн ажлын 29 жилийн туршлага, мэргэжлийн мэдлэгийн суурьтай байсан маань сургалтын агуулгад суралцах болон буцаж ирээд сурсан мэдсэнээ ажил хэрэг болгоход тус дөхөм болсон гэж бодож байна.

Сургалтын агуулгын тухайд : 2011 оны 11 сард Жайка-гийн Монгол дахь төлөөлөгчийн газарт Жайкагийн ажилтнууд, бусад орны сургалтанд оролцогчид, Японы судлаач, багш нарын оролцсон видео конференц болсон. Миний явуулж буй үйл ажиллагааг их сайшааж байсан нь үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх бас нэгэн түлхэц болж өгсөн.

Буцаж ирсний дараах дэмжих тогтолцооны тухайд : Холбоонд гишүүнээр элсэн Жайка-ийн сургалтын дараах дэмжлэг (Follow up cooperation)-ийн талаар мэдэж, хүсэлтээ гаргасан. Мөн мэргэжилтэн, багш зэрэг өргөн хүрээний боловсон хүчинтэй байсан ба семинар хэрэгжүүлсэнээр маш олон хүмүүсээс зөвөлгөө авч, мэргэжлийн бус мэдлэгээ өргөжүүлж чадсан.

【Бусад санал сэтгэгдэл】

7 хоног тутмын “Хөдөлмөр” сонины 2011 оны 10 сарын дугаарт мөн “Эрүүл мэнд-Инээмсэглэл” сэтгүүлд миний тухай нийтлэл нийтлэгдэж байсан.

Жайка-д хандан хөдөө орон нутгийн сувилалч нарт орчин үеийн сувилахуйн ухаанд суралцах боломжоор хомс байдаг тул тэдэнд зориулсан “Шинэ сувилалчийг сургах арга зүй” хөтөлбөрийг хэрэгжүүлэхэд, мөн сургалтанд оролцох боломжоор хангаж өгөхийг хүсэх байна.